



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2023 ОНЫ
БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

АУДИТЫН КОД: **ӨВА-2024/26-13-ШТА-ГА**



Арвайхээр хот
2024 он

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор **О.Батжаргал**
Утас: 70323253, цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn
Аудитын менежер Д.Гансүх,
Утас: 70323833, цахим хаяг: Gansukhd@audit.gov.mn
Ахлах аудитор: П.Хорлоосүрэн,
Утас: 70323108, цахим хаяг: Khorloosuren@audit.gov.mn
Аудитор: Ө.Ринчинмядаг,
Утас: 70323108, цахим хаяг: Rinchinmyadagu@audit.gov.mn
Аудитор: Р.Энхзул,
Утас: 70323108, цахим хаяг: Enkhzulr@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой
нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn



АГУУЛГА

АГУУЛГА.....	1
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.....	2
ГРАФИК, ДҮРСЛЭЛ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ.....	3
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ.....	4
Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт үр дүн, үр нөлөө.....	4
БҮЛЭГ 1. СУМЫН ОНХС-Д ХУУЛЬД ЗААСАН ЭХ ҮҮСВЭРИЙГ БҮРЭН НЭМЖ ТӨЛӨВЛӨӨГҮЙ, АЙМГИЙН ОНХС-ААС ИРГЭДИЙН САНАЛД ТУСГАГДААГҮЙ АЖЛЫГ ТӨЛӨВЛӨЖ, БАТАЛСАН БАЙНА.....	7
1.1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан боловч сумын ОНХС-ийн бусад орлогыг хуульд заасан эх үүсвэрээр бүрэн төлөвлөөгүй байна.....	7
1.2. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөсөн ч иргэдийн саналаар эрэмбэлэгдээгүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.....	11
БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ЗАРИМ ТАХ НЬ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХОЛБОГДОХ ХУУЛИЙН ЗААЛТЫГ ЗӨРЧСӨН, ЧАНАР МУУТАЙ ХИЙГДСЭН, ХУГАЦААНДАА ДУУСААГҮЙ, АШИГЛАЛТАД ОРООГҮЙ БАЙНА.....	18
2.1. Аймаг болон зарим сумд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХА тухай хуулийн зарим заалтыг зөрчсөн байна.....	18
2.2. Аймаг, сумдын 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 448.3 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээ чанаргүй хийгдсэн байна.....	21
2.3. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон зарим ТАХ гэрээнд заасан хугацаанд хийж дуусгаагүй, хүлээн авч ашиглалтад оруулаагүй байна.....	23
Бүлэг 3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, тайлагнах ажлыг аймаг болон зарим сумд хэрэгжүүлж ажиллаагүйгээс зарим ажил чанаргүй хийгдэж он дамжин хэрэгжиж байна.....	25
3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад аймгийн ИТХ, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт тавьж ажиллаагүй байна.....	25
3.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтээ үнэн зөв, журмын дагуу тайлагнаагүй, зарим ТАХ дуусаагүй тул тайлан, бүртгэлд тусгаагүй байна. 26	
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ.....	Error! Bookmark not defined.
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ХАРИУ.....	Error! Bookmark not defined.
ДҮГНЭЛТ.....	30
САНГИЙН ЯАМАНД САНАЛ:.....	30
ЗӨВЛӨМЖ.....	31
Хавсралт-1.....	32
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ.....	Error! Bookmark not defined.



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
УИХ	Улсын их хурал
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ГРАФИК, ДҮРСЛЭЛ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1	ОНХС-ийн орлогын эх үүсвэр сумдаар	6
Хүснэгт 2	ОНХНС болон улсын төсвөөс 2023 онд Өвөрхангай аймагт хуваарилсан санхүүжилт орлогын төрлөөр	7
Хүснэгт 3	ОНХНС-ийн санхүүжилтийн сарын хуваарийн төлөвлөгөө, гүйцэтгэл	7
Хүснэгт 4	Аймгийн ОНХС-аас сумдад олгох орлогын шилжүүлгийн хуваарь, хуваарьт орсон өөрчлөлт, гүйцэтгэл	8
Хүснэгт 5	Сумдын нэмэлт эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэл	9
Хүснэгт 6	Сумдын Малын тоо толгойн албан татварын төлөвлөгөө, гүйцэтгэл	9
Хүснэгт 7	Сумдын ОНХС-ийн санхүүгийн тайлангаарх авлагыг 2023 оны ОНХС-ийн эх үүсвэр төлөвлөлт харьцуулалт	10
Хүснэгт 8	Аймаг, сумдын ОНХС-ийн төлөвлөлтийн шатанд иргэдээс санал авсан тоо санал авсан хэлбэрээр	12
Хүснэгт 9	Зарим сумдын БИНХ-ын ирцын тоо	14
Хүснэгт 10	Бодлогын баримт бичгийн жагсаалт	15
Хүснэгт 11	Тайлан хүргүүлэх хугацаа, мэдээлэл	26
Дүрслэл 1	ОНХС-ийн төлөвлөлтөд иргэдийн санал хураалт явагдах үе шатууд	11
Дүрслэл 2	ОНХС-ийн төлөвлөлтөд анхан шатанд иргэдийн санал хураалт авах төрлүүд	12
Дүрслэл 3	ОНХС-ийн төлөвлөлтөд анхан шатанд иргэдээс санал хураалт төрлөөр	13
Дүрслэл 4	Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн ТАХ-ний ангилал	17
Дүрслэл 5	Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн ТАХ-ний ангилал	18
Дүрслэл 6	Сумдын Малын тоо толгойн албан татварын орлогоос 2023 онд хэрэгжүүлсэн ТАХ-ний ангилал	18
Зураг 1	Хужирт сумын Төрийн албан хаагчийн түрээсийн орон сууц	20
Зураг 2	Баянгол сумын ЕБС-ийн дотуур байрны халуун ус, угаалга, хатаалгын өрөөг тохижуулах ажил	21
Зураг 3	Төслөөр хийгдэж буй Баянгол сумын ЕБС-ийн дотуур байрны ариун цэврийн байгууламжтай болгох ажлын явц	21
Зураг 4	Баянгол сумын ЕБС-ийн гал тогооны хоол үйлдвэрлэлийн өрөөний засвар	21
Зураг 5	Баянгол сумын ЕБС-ийн дээвэр засвар	21
Зураг 6	Баян-Өндөр сумын ЭМТ-ийн шүдний кабинет	22
Зураг 7	Гучин-Ус сумын 3-р багийн төвийн барилга	22
Зураг 8	Арвайхээр сумын 8, 12 дугаар багийн тоглоомын талбай	24



АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит нэр:

Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт үр дүн, үр нөлөө

Аудитын код:

ӨВА-2024/26-13-ШТА-ГА

Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын “Төрийн аудитын байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай” А/152, “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2023 оны А/162, “Аудитын сэдэв батлах тухай” 2023 оны А/100 дугаар тушаалыг тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аудитыг хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт:

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-т байдалд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх асуудлыг тус тус хамруулсан.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад аймаг, сумын ИТХ, ЗДТГ, СТСХ, ХБТХОХ, ГХБХБГ, аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны орлогын бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналтай холбоотой үйл ажиллагааг хамруулсан.

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн ТАХ-ний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөв, ажлын тоо хэмжээ, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ түүний хэрэгжилт, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагуудаас хяналт хийсэн ажлын тайланг хамруулан төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн хүрээнд судалгаа, шинжилгээ хийсэн.

Аудитад хэрэглэсэн арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-3:2020, 6817-5:2020, 6817-7:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон MNS



6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудит, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандартын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг үндэслэн тулган баталгаажуулалтыг хийж, тухайн асуудал хариуцсан албан тушаалтнаас асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг горимыг хэрэгжүүлж, аудитын асуудлын шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт боловсруулан зөвлөмж бэлтгэлээ.

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль,
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
- МУЗГ-ын 2017 оны 230 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэг тооцох аргачлал"
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"
- МУЗГ-ын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан (2023 оны 278 дугаар тогтоолоор шинэчилсэн) "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах тайлагнах журам"
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"
- Дээрх хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, аймгийн ИТХ, Засаг даргын Захирамж, бусад эрхийн актууд
- Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, ажил гүйцэтгэх гэрээ

Аудитыг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал хянан удирдаж, аудитын менежер Д.Гансүх үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Хорлоосүрэн, аудитор Ө.Ринчинмядаг, Р.Энхзул нар хийж гүйцэтгэв. Аудитын урьдчилсан судалгааны ажлыг 2024 оны 3 дугаар сарын 20-ний өдрөөс эхэлж төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитыг гүйцэтгэж, тайлан, дүгнэлт, зөвлөмж болон холбогдох судалгааны хамт 2024 оны 7 дугаар сарын 04-ний өдөр Архангай аймаг дахь ТАГ-т хүргүүлэв.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудит хийх багийн бүрэлдэхүүн



Үндсэн мэдээлэл:

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулийн 18 дугаар зүйлд ОНХНС болон улсын төсвөөс ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг анх 9,808.2 сая төгрөгөөр баталсан ба тодотгол хийсэн нэмэлт өөрчлөлтөөр 12,166.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсвөөс 11,267.9 сая төгрөг, “Тогтвортой амьжиргаа-3” төслөөс 907.4 сая төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөжээ.

ОНХС-ийн харилцах дансны эхний үлдэгдэл аймгийн хэмжээнд 3,721.3 сая төгрөг, тайлант онд нийт 14,257.9 сая төгрөгийг төвлөрүүлж, 14,419.1 сая төгрөгийг зарцуулснаар эцсийн үлдэгдэл 3,560.1 сая төгрөг болсон байна. Үүнийг хүснэгтээр задлан харуулбал:

Хүснэгт 1. ОНХС-ийн орлогын эх үүсвэр сумдаар /мян.төг/

Аймаг, сумын нэр	ОНХС-ийн 2023 оны эхний үлдэгдэл	ОНХНС болон улсын төсвөөс	Тогтвортой амьжиргаа-3 төсөл	Малын тоо толгойн албан татвар	Нийт эх үүсвэр	Нийт зарлагын дүн	2023 оны эцсийн үлдэгдэл
Баян-Өндөр	76,717.5	234,032.0	33,428.8	76,728.0	344,188.8	356,162.5	64,743.8
Бүрд	67,065.10	247,929.1	27,140.9	91,663.5	366,733.5	326,832.0	106,966.6
Бат-Өлзий	268,115.4	517,976.8	62,149.7	109,815.9	689,942.4	713,410.3	244,647.5
Баруунбаян-Улаан	79,742.9	244,567.9	67,816.0	48,063.9	360,447.8	358,515.3	81,675.4
Баянгол	49,571.7	219,778.5	37,236.6	177,877.4	434,892.5	328,188.1	156,276.1
Гучин-Ус	26,080.8	207,688.6	28,649.5	68,587.5	304,925.6	219,309.1	111,697.3
Есөнзүйл	107,986.7	283,817.8	28,768.4	60,537.9	373,124.1	419,380.1	61,730.7
Өлзийт	42,211.7	129,889.6	18,306.0	51,022.0	199,217.6	222,713.9	18,715.4
Зүүнбаян-Улаан	0.4	177,445.1	30,242.6	142,097.7	349,785.4	341,303.8	8,482.0
Хайрхандулаан	86,552.4	231,469.9	61,042.3	131,920.0	424,432.2	424,848.1	86,136.5
Нарийнтээл	72,633.9	267,419.7	38,142.8	55,768.5	361,331.0	350,594.7	83,370.2
Сант	154,759.1	199,055.3	33,556.6	131,771.3	364,383.2	271,250.8	247,891.5
Тарагт	155,965.0	183,932.8	24,056.0	54,498.8	262,487.6	244,256.1	174,196.5
Төгрөг	143,279.6	246,859.8	40,295.6	124,726.5	411,881.9	293,825.1	261,336.4
Уянга	28,202.6	451,527.5	50,828.7	145,000.0	647,356.2	369,508.3	306,050.5
Богд	290,031.3	613,094.9	79,277.4	187,379.8	879,752.1	803,943.4	365,840.0
Хужирт	117,120.8	280,410.0	45,769.5	86,596.2	412,775.7	216,955.4	312,941.1
Хархорин	242,571.5	600,388.3	101,172.4	224,389.3	925,950.0	964,209.3	204,312.2
Арвайхээр	156,952.8	655,693.0	99,639.9	113,976.5	869,309.4	747,733.0	278,529.2
Аймгийн төв	1,555,739.8	5,274,969.8			5,274,969.8	6,446,128.2	384,581.4
Нийт дүн	3,721,301.1	11,267,946.4	907,519.7	2,082,420.6	14,257,886.7	14,419,067.4	3,560,120.3

Эх сурвалж: Аймгийн СТСХ-ээс ирүүлсэн судалгаа

ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд аймгийн хэмжээнд нийт 453 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр 18,495.5 сая төгрөгийг баталснаас 361 ТАХ-нд 14,419.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Аудитаар 5,865.3 сая төгрөгийн 15 албан шаардлага, 4,434.0 сая төгрөгийн 8 зөвлөмж өгч , 7,697.7 сая төгрөгийн үр өгөөж тооцов.



БҮЛЭГ 1. СУМЫН ОНХС-Д ХУУЛЬД ЗААСАН ЭХ ҮҮСВЭРИЙГ БҮРЭН НЭМЖ ТӨЛӨВЛӨӨГҮЙ, АЙМГИЙН ОНХС-ААС ИРГЭДИЙН САНАЛД ТУСГАГДААГҮЙ АЖЛЫГ ТӨЛӨВЛӨЖ, БАТАЛСАН БАЙНА.

1.1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан боловч сумын ОНХС-ийн бусад орлогыг хуульд заасан эх үүсвэрээр бүрэн төлөвлөөгүй байна.

1.1.1. Орон нутгийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг Сангийн яаманд тооцож байгаа тул эх үүсвэрийн төлөвлөлтийг орон нутагт үзэх боломжгүй байна.

1.1.2. ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг баталсан аргачлалын дагуу илтгэлцүүрийг үндэслэн тогтоож, хуваарилсан байна. Улсын төсвийн орлогын бүрдүүлэлт, ОНХС-ийн эх үүсвэрийн орлоготой холбоотой 2023 онд нийт 241.1 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосон байна.

ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3¹ дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-д заасны дагуу илтгэлцүүрүүдийг үндэслэн тогтоосон байна. ОНХНС болон улсын төсвөөс 2023 онд Өвөрхангай аймагт нийт 12,166.4 сая төгрөгийн санхүүжилт хуваарилагдсан бөгөөд эх үүсвэрийн задаргаагаар харуулбал:

Хүснэгт 2. ОНХНС болон улсын төсвөөс 2023 онд Өвөрхангай аймагт хуваарилсан санхүүжилт орлогын төрлөөр /сая.төг/

№	Орлогын нэр төрөл	Төлөвлөгөө	Эзлэх хувь
1	"Тогтвортой амьжиргаа 3" төслийн урамшуулал, дэмжлэг	907.52	7.46
2	АМ-ын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	44.71	0.37
3	АМ-ын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	182.00	1.50
4	Итгэлцүүрээр хуваарилагдсан дүн	11,032.14	90.68
ДҮН		12,166.4	100

Эх сурвалж: Сангийн яамны тоон мэдээлэл

ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн хуваарийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 3. ОНХНС-ийн санхүүжилтийн сарын хуваарийн төлөвлөгөө, гүйцэтгэл /сая.төг/

Огноо	ОНХНС-ийн орлогын төлөвлөлт		ОНХНС-аас олгосон санхүүжилт	Зөрүү
	Анх батлагдсан	Тодотгол		
1 сар	0	0	-	-
2 сар	650.6	650.6	650.6	-
3 сар	867.4	867.4	848.9	(18.5)
4 сар	943.0	943.0	866.6	(76.3)
5 сар	1,774.9	1,774.9	1,720.5	(54.4)
6 сар	867.4	867.4	813.0	(54.4)
7 сар	943.0	1,227.6	1,035.4	(192.2)
8 сар	867.4	1,152.0	1,413.6	261.6
9 сар	867.4	1,152.0	1,145.0	(7.0)
10 сар	688.3	1,189.8	1,126.0	(63.8)
11 сар	650.6	1,152.0	1,158.4	6.4
12 сар	688.3	1,189.8	1,147.2	(42.6)

¹ 59.3.Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тухайн жил орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг тодорхойлохдоо дараах итгэлцүүрийг үндэслэн тогтооно:

59.3.1.орон нутгийн хөгжлийн индекс;

59.3.2.хүн амын тоо;

59.3.3.хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ;

59.3.5.өмнөх жилийн төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны үнэлгээ.

Дүн	9,808.2	12,166.4	11,925.3	(241.1)
-----	---------	----------	----------	---------

Эх сурвалж: Аймгийн СТХС-ийн тоон мэдээлэл

Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1.²-д заасны дагуу тодотгол хийгдсэн. Дээрх хүснэгтээс харахад 3-7 саруудад санхүүжилт тодорхой хэмжээнд хуваариас дутуу олгогдсон, 8 сард илүү орсон байна. Улсын төсвийн орлогын бүрдүүлэлт, ОНХС-ийн эх үүсвэрийн орлоготой холбоотой 2023 онд нийт 241.1 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгогдсон байна.

1.1.3. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумын ОНХС-д олгох орлогын илтгэлцүүрүүдийг үндэслэн хуваарилж, төлөвлөгөөний дагуу 19 суманд нийт 6,650.3 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгожээ.

Аймгийн ОНХС-аас 2023 онд сумын Орон нутгийн хөгжлийн санд орлогын шилжүүлгийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2.³-д заасны дагуу, Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-д заасан илтгэлцүүрүүдийг үндэслэн хуваарилж, төлөвлөгөөний дагуу санхүүжилтийг сумдад бүрэн олгосон байна.

Хүснэгт 4. Аймгийн ОНХС-аас сумдад олгох орлогын шилжүүлгийн хуваарь, хуваарьт орсон өөрчлөлт, гүйцэтгэл /сая.төг/

№	Сумын нэр	Төлөвлөгөө			Сумдад олгосон санхүүжилт	Зөрүү
		Сумдын ОНХС-д хуваарилагдах суурь зардал	Аймгийн ИТХ-ын 2022 оны 15/06 тогтоолоор анх батлагдсан төсөв	Аймгийн ИТХ-ын 2023 оны 20/10 тогтоолоор баталсан тодотгосон төсөв		
1	Арвайхээр	755.3	615.2	755.33	755.33	(0.00)
2	Баруунбаян-Улаан	312.2	260.0	312.38	312.38	(0.00)
3	Бат-Өлзий	472.4	390.4	499.10	499.10	(0.00)
4	Баянгол	257.0	210.0	257.02	257.02	(0.00)
5	Баян-Өндөр	267.5	217.4	267.46	267.46	(0.00)
6	Богд	680.3	554.4	692.37	692.37	(0.00)
7	Бүрд	249.5	207.4	275.07	275.07	(0.00)
8	Гучин-Ус	236.2	191.9	236.34	236.34	(0.00)
9	Есөнзүйл	191.1	156.4	191.09	191.09	(0.00)
10	Зүүнбаян-Улаан	207.5	169.6	207.69	207.69	(0.00)
11	Нарийнтээл	287.1	237.8	305.56	305.56	(0.00)
12	Өлзийт	148.2	120.4	148.20	148.20	(0.00)
13	Сант	232.6	190.1	232.61	232.61	(0.00)

² 34.2.Засаг дарга дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ:

34.2.1. дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон;

³ 59.2.Аймаг, нийслэл нь Орон нутгийн хөгжлийн сангаас болон улсын төсвөөс олгосон шилжүүлгийг доор дурдсанаар сум дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд хуваарилна:

59.2.1.энэ хуулийн 60.11-д заасан үйлчилгээний зардалд ногдох хэсгийг сум дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд шилжүүлэх;

59.2.2.энэ зүйлийн 59.2.1-д зааснаас бусад хэсгийн 50-аас доошгүй хувийг хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилах;

59.2.2.1.хүн амын тоо;

59.2.2.2.нутаг дэвсгэрийн хэмжээ;

59.2.2.3.ашигт малтмал болон газрын тосны ашиглалтын талбайн хэмжээ.

59.2.3.улсын төсвөөс аймаг, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн санд энэ хуулийн 60.2.7-д заасан орлогын шилжүүлгийг 60 дугаар зүйлийн 60.6-д заасан хувь хэмжээгээр хуваарилах.

59.2.4.энэ хуулийн 59.1.3, 60.2.5-д заасан эх үүсвэрийг хандивлагч талаас болон урамшуулал, дэмжлэг олгогч байгууллагаас хүлээн авагч талыг тусгайлан заасан тохиолдолд тухайн сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд шууд хуваарилах ба итгэлцүүрээр хуваарилах хөрөнгөд тооцохгүй.



14	Тарагт	203.2	165.9	207.99	207.99	(0.00)
15	Төгрөг	283.7	231.9	284.80	284.80	(0.00)
16	Уянга	439.4	360.4	458.49	458.49	(0.00)
17	Хайрхандулаан	287.5	240.2	292.51	292.51	(0.00)
18	Хархорин	701.6	573.2	701.56	701.56	(0.00)
19	Хужирт	324.7	265.1	324.73	324.7	(0.00)
	Нийт дүн	6,536.9	5,357.9	6,650.3	6,650.3	(0.02)

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын тогтоол, аймгийн СТСХ-ийн тоон мэдээлэл

1.1.4. Бат-Өлзий, Есөнзүйл, Сант, Төгрөг, Уянга, Хужирт сумууд 2023 онд ОНХС-ийн бусад орлого нийт 216.08 сая төгрөг төлөвлөн 250.19 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэгт зааснаар ОНХС-ийн орлого нь дараах эх үүсвэрүүдээс бүрдэнэ гэж заасан.⁴

Бат-Өлзий суманд 2 төрлийн, Есөнзүйл суманд 1 төрлийн орлого нэмж төлөвлөн сумын ОНХС-ын эх үүсвэрийг нэмэгдүүлсэн, Сант сум 1 төрлийн орлого нэмж төлөвлөсөн ч орлого биеллээгүй байна. Харин Төгрөг, Уянга, Хужирт сумдад төлөвлөөгүй орлогууд орсон байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 5. Сумдын нэмэлт эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэл /сая.төг/

№	Сумын нэр	ТТХ-ийн 60.2.4 "Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон эх үүсвэр"		ТТХ-ийн 60.2.5 "тухайн ОНХ-ийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив тусламж, ОУБ-ийн төсөл хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг"		Бусад орлого	
		төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц
1	Бат-Өлзий	70.0	70.0	11.03	11.03		
2	Есөнзүйл					121.5	121.5
3	Сант					13.55	
4	Төгрөг						2.35
5	Уянга						43.9
6	Хужирт						1.45
	Нийт дүн	70.0	70.0	11.03	11.03	135.05	169.16

Эх сурвалж: Сумдын ИТХ-ын тогтоолууд, ОНХС-ийн аудитын судалгаа

Хүснэгт 6. Сумдын Малын тоо толгойн албан татварын төлөвлөгөө, гүйцэтгэл /мян.төг/

№	Сумын нэр	Малын тоо толгойн албан татварын төлөвлөгөө /Сумын ИТХ-ын тогтоолоор баталсан дүн/			Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувь
		Өмнөх оны үлдэгдэл	Тайлант оны ногдуулалт	Нийт дүн			
	2	3	4	5=3+4	6	7=6-5	8
1	Нарийнтээл	117,334.40	152,674.0	270,008	55,768.5	(214,239.95)	20.65
2	Есөнзүйл	44,698.30	178,702	223,400	60,537.90	(162,862.00)	27.10
3	Баян-Өндөр	20,000.00	190,275	210,275	76,728.0	(133,546.50)	36.49
4	Бүрд	155,200.00	95,000.00	250,200	91,663.50	(158,536.50)	36.64
5	Тарагт	40,862.00	83,193.9	124,056	54,498.8	(69,557.10)	43.93
6	Баруунбаян-Улаан	24,591.80	72,486	97,078	48,063.9	(49,013.92)	49.51

⁴1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг;

2. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 100 хувь, ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувь ;

3. Тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг; Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр;

4. Малын тоо толгойн албан татварын орлого;

5. Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан гэрээний дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламж.

Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт үр дүн, үр нөлөөнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

7	Баянгол	147,495.00	206,620	354,115	177,877.4	(176,237.40)	50.23
8	Гучин-Ус	18,000.00	105,000	123,000	68,587.5	(54,412.50)	55.76
9	Бат-Өлзий	1,293.80	176,700	177,994	109,815.9	(68,177.91)	61.70
10	Хайрхандулаан	-	210,000	210,000	131,920.0	(78,080.00)	62.82
11	Сант	-	191,855	191,855	131,771.3	(60,083.70)	68.68
12	Өлзийт	34,000.00	36,000	70,000	51,022.0	(18,978.00)	72.89
13	Арвайхээр	44,000.00	100,000	144,000	113,976.5	(30,023.50)	79.15
14	Богд	109,996.00	123,300	233,296	187,379.8	(45,916.45)	80.32
15	Төгрөг	58,409.00	83,391.4	141,800	124,726.5	(17,073.90)	87.96
16	Зүүнбаян-Улаан	70,000.00	80,312	150,312	142,097.7	(8,214.60)	94.53
17	Уянга	-	145,000	145,000	145,000.0	-	100.00
18	Хархорин	60,000.00	150,000	210,000	224,389.3	14,389.30	106.85
19	Хужирт	-	80,000	80,000	86,596.2	6,596.20	108.25
Нийт дүн		945,880.3	2,460,508.7	3,406,389.0	2,082,420.6	(1,323,968.4)	65.45

Эх сурвалж: Сумдын ИТХ-ын тогтоолууд, ОНХС-ийн аудитын судалгаа, Аймгийн 2023 оны төсвийн төслийн тооцоолол

Сумдын ОНХС-ийн 2023 оны жилийн эцсийн СТА-аар малын тоо толгойн албан татварын төвлөрүүлээгүй үлдэгдлийг санхүүгийн тайланд авлагаар бүрэн тусгуулсан. Сумдын татвар төвлөрүүлэлтийг харахад 2023 оны малын тоо толгойн албан татварын орлого дунджаар 65.45 хувьтай, нийт 8 сумын биелэлт 20.6-50.23 хувьтай биелэгдсэн нь орлого бүрдүүлэлт хангалтгүй байна. Хужирт, Хархорин сумууд 2023 оны Малын тоо толгойн албан татварын төлөвлөгөөг сумын ИТХ-ийн тогтоолоор баталсан дүнгээс бага төлөвлөж, гүйцэтгэл нь давж биелсэн байна.

Хүснэгт 7. Сумдын ОНХС-ийн санхүүгийн тайлангаарх авлагыг 2023 оны ОНХС-ийн төлөвлөлттэй харьцуулсан /мян.төг/

№	Сумын нэр	2023 оны жилийн эцсийн аудитлагдсан СТ-ын авлагын дүн		Малын тоо толгойн албан татварын өмнөх оны үлдэгдлийн төлөвлөгөө /Сумын ИТХ тогтоолоор баталсан дүн/	Авлага эхний үлдэгдэл зөрүү
		Эхний үлд	Эцсийн үлд		
1	2	3	4	5	6=3-5
1	Арвайхээр	70,220.80	88,574.55	44,000.00	26,220.80
2	Баруунбаян-Улаан	27,211.75	45,736.45	24,591.80	2,619.95
3	Бат-Өлзий	111,673.65	232,817.46	1,293.80	110,379.85
4	Баянгол	185,665.36	260,578.43	147,495.00	38,170.36
5	Баян-Өндөр	176,000.00	190,842.50	20,000.00	156,000.00
6	Богд	116,720.27	136,171.40	109,996.00	6,724.27
7	Бүрд	174,428.75	200,463.55	155,200.00	19,228.75
8	Гучин-Ус	61,784.60	40,533.00	18,000.00	43,784.60
9	Есөнзүйл	64,264.97	130,978.57	44,698.30	19,566.67
10	Зүүнбаян-Улаан	131,882.40	244,560.94	70,000.00	61,882.40
11	Нарийнтээл	100,416.00	197,321.55	117,334.40	(16,918.40)
12	Өлзийт	89,819.58	100,713.04	34,000.00	55,819.58
13	Сант	29,394.90	79,506.80	-	29,394.90
14	Тарагт	27,984.75	56,679.89	40,862.00	(12,877.26)
15	Төгрөг	120,875.58	84,434.49	58,409.00	62,466.58
16	Уянга	126,634.30	258,969.90	-	126,634.30
17	Хайрхандулаан	100,328.18	109,211.90	-	100,328.18
18	Хархорин	116,999.23	0	60,000.00	56,999.23
19	Хужирт	168,535.02	288,518.15	-	168,535.02
Нийт дүн		2,000,840.08	2,658,038.00	945,880.30	1,054,959.78

Эх сурвалж: Сумдын ИТХ-ын тогтоолууд, 2023 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд оны эхний авлагаас сумдын төлөвлөсөн Малын тоо толгойн албан татварын эхний үлдэгдлийг хасаж тооцоолоход нийт 1,054.96 сая төгрөгийн зөрүү гарч байна. Энэхүү авлагын зөрүүгээр сумдын ОНХС-ийн эх үүсвэр нэмэгдэх боломж байсан байна.



Сумууд ОНХС-ийн эх үүсвэрийг төлөвлөхдөө Малын тоо толгойн албан татварын өмнөх оны үлдэгдэл авлагыг тогтоолоор батлан эх үүсвэрийн төлөвлөлтөд тусгасан бол бусад авлагыг эх үүсвэртээ тусгаагүй байна./малжуулах төслийн эргэн төлөлт, өвс тэжээл олгосны авлага зэрэг нь эдгээр бусад авлагад багтсан/

Аймгийн СТСХ төсвийн төслийг хүлээн авах, тайлан нэгтгэхдээ ОНХС-ийн бусад авлагыг бүрэн тусгуулах шаардлагатай байна.

Аудитын илрүүлэлт

1. Сумдууд 2023 оны ОНХС-ийн эх үүсвэрт өмнөх жилүүдэд үүссэн нийт 1,054.96 сая төгрөгийн бусад авлагыг сумын ОНХС-ийн эх үүсвэрт төлөвлөж тусгаагүй байна.

1.2. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөсөн ч иргэдийн саналаар эрэмбэлэгдээгүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

1.2.1. Өвөрхангай аймгийн 19 сумын 112 багуудын санал асуулгын тооноос харахад иргэдээс анхан шатанд саналыг тэгш оролцоотой байдлаар авсан бол дараагийн шатны БИНХ-аар эрэмбэлэх явцад хурлын ирц хүчин төгөлдөр бус үед 24 баг хурлаа зохион байгуулж саналаа эрэмбэлжээ. Аймгийн ОНХС-ийн санхүүжилтээр хийгдэх ажлыг төлөвлөхдөө нээлттэй хэлэлцүүлэг явуулаагүй, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар заасан хугацаанд саналыг хэлэлцүүлээгүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх үед иргэдийн саналын үйл явц нь дараах байдлаар явагддаг. Үүнд:

Дүрслэл 1. ОНХС-ийн төлөвлөлтөд иргэдийн санал хураалт явагдах үе шатууд

НЭГДҮГЭЭР ҮЕ ШАТАНД	ХОЁРДУГААР ҮЕ ШАТАНД	ГУРАВДУГААР ҮЕ ШАТАНД	ДӨРӨВДҮГЭЭР ҮЕ ШАТАНД
Багийн түвшинд иргэдийн оролцоог хангах ажлыг төлөвлөх, иргэдийг мэдээллээр хангах;	Иргэдээс санал авах, саналыг нэгтгэж төслийн урьдчилсан жагсаалт бэлтгэх;	Багийн Иргэдийн Нийтийн Хурал (ИНХ)-аар төслүүдийг хэлэлцэн санал хурааж эрэмбэлэх, батлах;	ИНХ-ын шийдвэрийг сумын ЗДТГ-т уламжлах, ИНХ-ын шийдвэрийг иргэддээ мэдээлэх үйл ажиллагааны талаар багтаасан.

Эх сурвалж: <https://tusuv-oronnutag.mof.gov.mn/>

Дээрх зурагт харуулснаар ОНХС-ийн иргэдийн саналыг авах үйл ажиллагаа нь эхлээд иргэдээс санал авах, дараа нь БИНХ-аар төслүүдийг хэлэлцүүлдэг.

Сүмдын иргэдээс анхны санал авах үе шатын талаар

Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын хавсралтаар баталсан “ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ”-ын 5 дугаар зүйлийн 5.2-д заасны дагуу баг, хорооны иргэдийн дунд олон нийтийн нээлттэй санал асуулгыг дараах хэлбэрээр явуулна гэж заасан. Үүнд:



Дүрслэл 2. ОНХС-ийн төлөвлөлтөд анхан шатанд иргэдийн санал хураалт авах төрлүүд

1. Санал асуулгын хуудас

- Санал асуулгын хэлбэрээр иргэдээс мэдээлэл авахдаа холбогдох журамд заасан “санал авах маягт”-ыг баг, хорооны иргэдэд хүргүүлж, саналыг авна.

2. Бүлгийн хэлэлцүүлэг

- Багийн хувьд 30-аас доошгүй /сумын төвөөс алслагдсан багийн хувьд 20-оос доошгүй/ иргэний бүрэлдэхүүнтэй бүлгийн ярилцлагыг бүлэг тус бүр зохион байгуулах ба ярилцлагын үеэр иргэдээс авсан саналыг хэлэлцүүлгийн тэмдэглэлд тусган хэлэлцүүлэгт оролцсон иргэдийн гарын үсгээр баталгаажуулна. /орон нутгийн иргэд өөрсдөд тулгамдаж буй асуудлаар нийтийн ашиг сонирхлыг илэрхийлж сайн дурын үндсэн дээр нэгдсэн бүлгийн зохион байгуулалт/

3. Цахим хэлбэр

- Цахим хэлбэр болон техник, технологийн дэвшилтэт бусад арга хэлбэрээр 30-аас доошгүй хоногийн турш тогтсон цахим хаяг, цахим хуудас, гар утасны программ ашиглан санал өгч буй иргэнийг баталгаажуулах боломжтойгоор ОНХС-ийн саналыг хүлээн авч, нэгтгэнэ.

Эх сурвалж: Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам

Аймаг, сумдын ОНХС-аас 2023 онд хэрэгжүүлэх ТАХ-ны саналыг авах эхний үе шат дараах байдлаар явагдсан байна. Үүнд:

Хүснэгт 8. Аймаг, сумдын ОНХС-ийн төлөвлөлтийн шатанд иргэдээс санал авсан тоо санал авсан хэлбэрээр

№	Сум, дүүргийн нэр	Саналын тоо /хэлбэр/			Нийт саналын тоо
		Цахим	Бүлгийн ярилцлага	Цаасаар	
1	Аймгийн ОНХС	1161	-	-	1,161
2	Арвайхээр	92	221	11,036	11,349
3	Баруунбаян-Улаан	38	-	1,748	1,786
4	Бат-Өлзий	-	-	6,589	6,589
5	Баянгол	5	28	7,193	7,226
6	Баян-Өндөр	8	-	6,886	6,894
7	Богд	-	-	6,191	6,191
8	Бүрд	-	-	4,467	4,467
9	Гучин-Ус	51	-	3,389	3,440
10	Есөнзүйл	-	-	2,149	2,149
11	Зүүнбаян-Улаан	-	-	7,163	7,163
12	Нарийнтээл	-	493	1,424	1,917
13	Өлзийт	18	2	2,517	2,537
14	Сант	390	3	3,307	3,700
15	Тарагт	84	715	7,628	8,427
16	Төгрөг	-	56	2,451	2,507
17	Уянга	1	2,357	10,804	13,162
18	Хайрхандулаан	18	27	5,808	5,853
19	Хархорин	1	-	10,770	10,771
20	Хужирт	126	20	17,745	17,891
	Нийт дүн	1,993	3,922	119,265	125,180

Эх сурвалж: ОНХС-ийн удирдлагын мэдээллийн систем



Өвөрхангай аймгийн 19 сумын 112 багуудын санал асуулгын тоог харахад иргэдээс анхан шатанд саналыг тэгш оролцоотой байдлаар авсан байна.

Дүрслэл 3. ОНХС-ийн төлөвлөлтөд анхан шатанд иргэдээс санал хураалт төрлөөр




Дээрх графикаас харахад аймгийн хэмжээний нийт 125,180.0 саналын 95 хувийг цаасаар, 3 хувийг бүлгийн ярилцлагаар, 2 хувийг цахимаар авсан байна. Энэ нь ОНХС-ийн санал авах аппликейшн ашиглалт Өвөрхангай аймгийн хэмжээнд бага, уламжлалт цаасан суурьтай санал хураалт их байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журамд өөрчлөлт орсноор анхан шатны санал хураалтын явцад иргэдийн оролцоог бүрэн хангах зохицуулалт хангалтгүй болж, хязгаарлагдсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” /хүчингүй болсон/	Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” /мөрдөж байсан/
5 дугаар зүйлийн 5.3.-д “Энэ журмын 5.2.1-д заасан хэлбэрээр санал авахдаа энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан жишиг маягтыг баг, хорооны өрх бүрд хүргүүлж, бүртгэл хөтлөн ирсэн саналыг энэ журмын 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу бүртгэж нэгтгэнэ.”	5 дугаар зүйлийн 5.3.-д “Энэ журмын 5.2.1-д заасан хэлбэрээр санал авахдаа энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан маягтыг баг, хорооны иргэдэд хүргүүлж, бүртгэл хөтлөн ирсэн саналыг энэ журмын 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу бүртгэж нэгтгэнэ.”

Сумдын БИНХ-аар төсөл хэлэлцэн, эрэмбэлэх үе шатын талаарх эрх зүйн зохицуулалтууд:

- “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 5 дугаар зүйлийн 5.8.-д “Баг, хорооны ИНХ-ын дарга дараагийн төсвийн жилд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг хэлэлцэх, санал хураах хуралдааныг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу хүчин төгөлдөр ирцтэйгээр 6 дугаар сард багтаан зохион байгуулна.”
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.6-д зааснаар БИНХ-ын хүчин төгөлдөр ирц гэдэг нь багийн иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд гурван өрх тутмаас, 400-аас дээш өрхтэй багт таван өрх тутмаас тус бүр нэгээс доошгүй хүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хуралдааныг хүчинтэйд тооцно.



Сумдын БИНХ-д оролцсон ирцийг тооцоолон үзэхэд дараах багууд хүчин төгөлдөр ирц хүрээгүй байхад ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг хэлэлцэн, эрэмбэлж баталсан байна. Үүнд:

Хүснэгт 9. Зарим сумдын БИНХ-ын ирцын тоо

№	Сумын нэр	Баг, хороо	2022 оны өрхийн тоо	Хүчин төгөлдөр ирц	БИНХ-ын ирц өрхөөр	Ирцийн хувь
1	Арвайхээр	13-р баг, Онги	1057	211	51	24%
2	Арвайхээр	5-р баг, Арвайхээр	1013	203	49	24%
3	Арвайхээр	1-р баг, Согоот	895	179	64	36%
4	Арвайхээр	11-р баг, Хүйс толгой	551	110	45	41%
5	Арвайхээр	4-р баг, Өлзийт	930	186	91	49%
6	Арвайхээр	7-р баг, Дэлгэрэхийн дэнж	640	128	64	50%
7	Арвайхээр	8-р баг, Рашаант	873	175	90	52%
8	Хархорин	1-р баг, Вангийн-Овоо	911	182	98	54%
9	Арвайхээр	9-р баг, Бурхи	732	146	84	57%
10	Арвайхээр	2-р баг, Эмт	731	146	85	58%
11	Бат-Өлзий	1-р баг, Улаан-Ам	315	105	62	59%
12	Арвайхээр	12-р баг, Зүлэгт	430	86	51	59%
13	Арвайхээр	10-р баг, Ноён	905	181	110	61%
14	Бат-Өлзий	3-р баг, Өвт	501	100	61	61%
15	Бат-Өлзий	5-р баг, Хүйтэн булаг	336	112	73	65%
16	Арвайхээр	3-р баг, Дэлгэрэх	679	136	90	66%
17	Уянга	6-р баг, Бөөрөлжүүт	369	123	83	67%
18	Бат-Өлзий	2-р баг, Бүрэгтий	446	89	62	70%
19	Бат-Өлзий	4-р баг, Зөрүүлэг	457	91	73	80%
20	Нарийнтээл	4-р баг, Цагаан-Овоо	290	97	80	83%
21	Бат-Өлзий	6-р баг, Улиастай	264	88	73	83%
22	Уянга	7-р баг, Өлт	385	128	109	85%
23	Хужирт	6-р баг, Дулаан	244	81	71	87%
24	Өлзийт	4-р баг, Гуулин	151	50	44	87%

Эх сурвалж: <https://www.1212.mn/> - Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, ОНХС-ийн удирдлагын мэдээллийн систем

Дээрх хүснэгтээс харахад Арвайхээр сумын багуудын ирц хангалтгүй байна.

Аймгийн ОНХС-д иргэдийн санал авах үе шат

“Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1⁵ -д заасны дагуу Өвөрхангай аймгийн Засаг даргын 2021 оны А/221 дүгээр захирамжаар томилогдсон аймгийн Засаг даргын Тамгын газрын ХОХБТХ-ийн даргаар ахлуулсан, 11 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Арвайхээр сумаас 20, Хархорин сумаас 6, Төгрөг сумаас 3, Тарагт сумаас 4 ажлыг ач холбогдлоор эрэмбэлэн аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх 18 ажлын урьдчилсан жагсаалтыг боловсруулсан байна. Тус 18 ажлыг олон нийтэд танилцуулан google form-г ашиглан санал авч 1161 хүн оролцсон байна. Мөн журмын 7 дугаар зүйлийн 7.5⁶-д урьдчилсан жагсаалтын нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулна гэж заасан бөгөөд 2022 онд тус хэлэлцүүлгийг зохион байгуулаагүй, 7.6⁷-д заасны дагуу Засаг даргын зөвлөлийн хурлаар 8 дугаар сарын 10-ны дотор хэлэлцүүлээгүй байна. Сумдаас ирүүлсэн саналыг бүрэн баталгаажуулж аваагүй байна.

Аудитын илрүүлэлт

⁵ 7.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг олон нийтийн оролцоотой төлөвлөх, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус ажлын хэсгийг байгаль орчин, газрын харилцаа, хөдөө аж ахуй, санхүү, төрийн сангийн асуудал хариуцсан ажилтан, холбогдох хэлтсийн албан тушаалтнууд, иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргаар ахлуулсан 9-өөс доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байгуулна.

⁶ 7.5.Урьдчилсан жагсаалтыг аймаг, нийслэлийн Иргэний танхимаар дамжуулан, нийтэд зар мэдээ хүргэсний үндсэн дээр нээлттэй хэлэлцүүлгийг жил бүрийн 7 дугаар сард багтаан зохион байгуулна.

⁷ 7.6.Ажлын хэсэг хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэн аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг ОНХС-ийн УМС-ийн маягтын дагуу хэвлэж жил бүрийн 8 дугаар сарын 10-ны өдрийн дотор Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

1. Иргэдийн анхан шатны саналыг хэлэлцэн эрэмблэх шатанд Арвайхээр, Бат-Өлзий, Уянга, Нарийнтээл, Хужирт, Өлзийт, Хархорин сумын 24 баг БИНХ-ын хүчин төгөлдөр ирц хүрээгүй байхад ажлыг эрэмблэн, жагсаалтыг баталсан байна.
2. Аймгийн ОНХС-ийн санхүүжилтээр хийгдэх ажлыг төлөвлөхдөө нээлттэй хэлэлцүүлэг явуулаагүй, зөвхөн цахимаар санал асуулга авах байдлаар урьдчилсан жагсаалтыг олон нийтэд хүргэсэн, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар заасан хугацаанд хэлэлцүүлээгүй байна.

1.2.2. Аймгийн ХБТХОХ-ээс иргэдийн саналаар 2023 онд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийхээр төлөвлөсөн 13 шинэ ажил, 19 суманд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 375 төсөл арга хэмжээг сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулан эрэмбэлсэн байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.2.6.-д аймаг, сумын “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх,” гэж заасан.

Хүснэгт 10. Бодлогын баримт бичгийн жагсаалт

№	Бодлогын баримт бичгийн төрөл	Бодлогын баримт бичгийн нэр
1	Урт	АЛСЫН ХАРАА-2050 /30 жилийн хугацаанд хэрэгжүүлэх/
2	Дунд	Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
3	Богино	Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, Орон нутгийн төсөв

Аймгийн ХБТХОХ-ээс иргэдийн саналаар 2023 онд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр нийт 5,152.98 сая төгрөгийн 13 шинэ ажлыг хийхээр төлөвлөсөн нь Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулсан байна.

Мөн журмын 6 дугаар зүйлийн 6.4.2-т багаас ирсэн саналыг нэгтгэж эрэмбэлэхдээ сумын хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөнө гэж заасан. Сумдын ИТХ-ын тогтоолоор 2023 онд 19 суманд хэрэгжүүлэхээр нийт 406 ТАХ-г баталсан бөгөөд эдгээр төсөл арга хэмжээг сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулан эрэмбэлсэн байна.

1.2.3. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ий ихэнх буюу 27 төрлийн 3,741.32 сая төгрөгийн ажил иргэдийн саналд тусгагдаагүй байна.

Төсвийн тухай хууль, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журамд заасан 9⁸ үндсэн нөхцөлүүдийг хангасан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг

⁸ 1. Хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх;

2. Сум, дүүргийн иргэдээр дэмжигдсэн сум, дүүргийн төсвөөр бие даан хэрэгжүүлэх боломжгүйгээс аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр хүргүүлсэн жагсаалтад орсон байх; /аймаг/

3. Тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх; /сум/

4. Зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй байх;

5. Сумын төвөөс алслагдсан баг, хорооны иргэдийн хамгийн олон саналыг авч эрэмбэлэгдсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг заавал багтаах;

аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлнэ гэж заасан. Аймгийн ОНХС-аас анх 14 ТАХ-г 5,152.96 сая төгрөгөөр хийхээр төлөвлөсөн боловч аймгийн ИТХ-ын 2022 оны 15/06 дугаар тогтоолоор 5,861.96 төгрөгийн 25 ажлыг хийхээр баталж, 4 удаа аймгийн төсвийн тодотгол хийж 47 төрлийн 7,041.07 сая төгрөгийн ТАХ хийхээр баталсан байна. Үүнээс иргэдийн саналд тусгагдаагүй 27 төрлийн 3,741.32 сая төгрөгийн ажлыг төлөвлөж баталсан байна. /Жагсаалтыг тайлангийн хавсралт-1 харуулав/

Холбогдох хууль, журмын дагуу иргэдийн санал аваагүй ТАХ-г сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталж буй зөрчил бүрэн арилахгүй байна.

Баян-Өндөр сум нь ОНХС-ийн 2023 оны санхүүжилтээр иргэдийн саналд тусгагдаагүй, эрэмбэлэгдээгүй дараах ажлуудыг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Халуун усны барилгын цооног хийх ажилд 19.0 сая төгрөг;
- Төмс хүнсний ногооны зорь, дотоод тохижилтын засварын ажил 16.7 сая төгрөг.

Аудитын илрүүлэлт

1. Аймгийн ОНХС-аас иргэдийн саналд тусгагдаагүй 27 төрлийн 3,741.32 сая төгрөгийн ажлыг төлөвлөж баталсан байна. Жагсаалтыг тайлангийн хавсралт-1 харуулав.

2. Баян-Өндөр сум нь ОНХС-ийн 2023 оны санхүүжилтээр иргэдийн саналд тусгагдаагүй 35.7 сая төгрөгийн 2 ажлыг төлөвлөн, хэрэгжүүлсэн байна.

1.2.4. Аймаг, суманд 2023 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ- төлөвлөхдөө хууль, журамд заасан чиг үүрэгт хамаарах төсөл, арга хэмжээг тусгасан байна.

Төсвийн тухай хууль, ОНХС-ийн үйл ажиллагааны журамд аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-г дараах байдлаар тусгасан байна.

Аймгийн түвшинд	Сумын түвшинд
1.Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэх ухаан, цахим технологи;	1.Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэх ухаан, цахим технологи;
2.Дэд бүтцийг сайжруулах, зам гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ;	2.Дэд бүтцийг сайжруулах, зам гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ;
3.Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах;	3.Орчны тохижилт, ногоон байгууламжийг сайжруулах, байгаль орчныг хамгаалах;
4.Ундны усны хангамж, эрүүл ахуйг сайжруулах;	4.Ундны усны хангамж, эрүүл ахуйг сайжруулах;
5.Аймаг, хотын хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн техник эдийн засгийн үндэслэл (цаашид ТЭЗҮ гэх), зураг төсөв боловсруулах;	5.Сум, дүүргийн хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах;
6.Аймгийн бэлчээрийн менежмент болон мал сүргийн чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлэх;	6.Мал аж ахуйг хөгжүүлэх, бэлчээрийн менежментийг сайжруулах;
7.Өрхийн орлогыг дэмжих чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт;	7.Өрхийн орлогыг дэмжих чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт;
8.Ажлын байр бий болгох.	8.Ажлын байр бий болгох;
	9.Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх сургалт, сурталчилгаа.

6. Санхүүжүүлэх эх үүсвэрийг өөр бусад эх үүсвэртэй уялдуулан төлөвлөсөн байх;

7. Санхүүжүүлэхээр батлагдан ажлын гүйцэтгэл нь баталгаажсан боловч тухайн онд санхүүжилт хийгдээгүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тус бүрийг нэгдсэн жагсаалтад оруулах;

8. Өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлтийг гаргасан байх;

9. ТАХ-ний өмчлөл, цаашидын ашиглалтын урсгал зардал, шинээр бий болох орон тоог орон нутаг өөрөө хариуцах.

Сумын ОНХС-д төвлөрөх Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр Төсвийн тухай хууль, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журамд заасан чиг үүргийн хүрээнд 12⁹ төрлийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.

Сумдын ОНХС-ийн төлөвлөлтөөс харахад Баруунбаян-Улаан, Баян-Өндөр, Гучин-Ус, Есөнзүйл, Зүүнбаян-Улаан, Тарагт, Хархорин, Хужирт сумууд 2023 онд ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлыг сумын ИТХ-ын тогтоолоор батлахдаа малын тоо толгойн албан татварын орлогоор хийгдэх ажлыг тусад нь төлөвлөж тусгаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 4 дүгээр зүйлийн 4.7¹⁰-д ОНХС-ийн хөрөнгийг зарцуулахыг хориглох заалтуудыг тусгасан. Аймаг болон сумын 2023 оны ОНХС-аас хориглох заалттай ТАХ-г төлөвлөөгүй байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-г ангиллаар харуулбал.

Дүрслэл 4. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн ТАХ-ний ангилал




График 4-с харахад аймагт ОНХС-н хөрөнгөөр дэд бүтцийг сайжруулах, зам, гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээний ажлыг хамгийн их хийсэн бол ундны усан хангамж, эрүүл ахуйг сайжруулах, өрхийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт, ажлын байр бий болгох төрлийн ажлуудыг огт төлөвлөөгүй байна.

⁹ 1.Бэлчээрийн менежментийг сайжруулах;
2.Бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх;/хөдөөгийн хүн, малын усан хангамжийг нэмэгдүүлэх, хөв цөөрөм, далан байгуулах, булгийн эхийг хашиж хамгаалах/
3.Малын эрүүл мэндийг хамгаалах;
4.Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх;
5.Малын чанарыг сайжруулах;
6.Гэмт халдлага, гамшигаас хамгаалах;
7.Хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх;
8.Малын тэжээлийн ургамал тариалах;
9.Тэжээлийн нөөц бүрдүүлэх;
10.Байгаль орчныг хамгаалах;
11.Хортон мэрэгчидтэй тэмцэх/байгаль орчин, хүн, мал, амьтанд халгүй дэвшилтэт арга, технологи ашиглах/;
12.Малчдад зориулсан сургалт, сурталчилгаа.
¹⁰ 1. Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүрэгээс бусад хөтөлбөр, арга хэмжээ.
2. Улс төрийн нам, эвсэл, түүний харьяа аливаа төрлийн байгууллага, төрийн бус байгууллагын зарлага;
3. Үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн ёслолын зардал;
4. Нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа;
5. Зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа, батлан даалт гаргах, хохирлыг нөхөн төлөх үүрэг авах;
6. Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ;
7. Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал.




Дүрслэл 5. Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн ТАХ-ний ангилал



График 5-с харахад сумдад ОНХС-н хөрөнгөөр дэд бүтцийг сайжруулах, зам, гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээний ажил хамгийн их төлөвлөгдөн хийгдсэн бол өрхийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт хамгийн бага хийгджээ.

Дүрслэл 6. Сумдын Малын тоо толгойн албан татварын орлогоос 2023 онд хэрэгжүүлсэн ТАХ-ний ангилал



Харин малын тоо толгойн албан татварын орлогын эх үүсвэрээр малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлууд хамгийн их хийгдсэн бол хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх ажил хамгийн бага тоотой төлөвлөгдөн, хийгдсэн байна.

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ЗАРИМ ТАХ НЬ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХОЛБОГДОХ ХУУЛИЙН ЗААЛТЫГ ЗӨРЧСӨН, ЧАНАР МУУТАЙ ХИЙГДСЭН, ХУГАЦААНДАА ДУУСААГҮЙ, АШИГЛАЛТАД ОРООГҮЙ БАЙНА.

2.1. Аймаг болон зарим сумд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХА тухай хуулийн зарим заалтыг зөрчсөн байна.



2.1.1. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан боловч Баянгол, Нарийнтээл сумд 109.5 сая төгрөгийн ижил төрлийн 7 төсөл, арга хэмжээг ТБОНӨХБАҮХА тухай хуулийн заалтыг зөрчин гэрээ байгуулсан байна.

Аймгийн хэмжээнд нийт 16,622.7 сая төгрөгийн 388 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна.

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа 7,152.7 сая төгрөгийн 41 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг нээлттэй тендер шалгаруулалтаар, 306.8 сая төгрөгийн 19 төсөл, арга хэмжээг олон нийтийн оролцоотой худалдан авалтаар, 5,462.9 сая төгрөгийн 100 төсөл, арга хэмжээг харьцуулалтын аргаар шалгаруулж, 2,719.9 сая төгрөгийн 179 төсөл, арга хэмжээнд шууд гэрээ байгуулж, 980.4 сая төгрөгийн 49 төсөл, арга хэмжээнд төсөвт өртөг хүрээгүй болон он дамжин хэрэгжих шалтгаанаар хийгдээгүй байна.

ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д “8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно”-д гэсэн заалтыг зарим сумууд зөрчиж шууд гэрээ байгуулсан байна. Үүнд:

- Баянгол сумын тохижилт, үйлчилгээний зардал-19.5 сая төгрөг, цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтыг нэмэгдүүлэх-19.0 сая төгрөг, ЕБС-ийн гал тогооны барилгын өрөөг засварлах-10.0 сая, дотуур байрны халуун ус, угаалга, хатаалгын өрөөг тохижуулах-15.0 сая, хичээлийн байрны цонхны амлагаа, жийрэг резин солих-19.0 сая төгрөг зэрэг ижил төрлийн 38.5 сая төгрөгийн 2 ажил, 44.0 сая төгрөгийн 3 ажил
- Нарийнтээл сум нь ижил төрлийн трактор хадлангийн тоног төхөөрөмж /бутлагч/-13.5 сая, /клюд/-13.5 сая төгрөг нийт 27.0 сая төгрөгийн ажил

Аймгийн Худалдан авах ажиллагааны газраас зарласан нийт 20 нээлттэй тендерээс 5 тендерийн урилгыг өдөр тутмын сонинд нийтлээгүй байна. Үүнд:

- Баянгол сумын тохижилт, үйлчилгээний зардал 100.0 сая төгрөг
- Хаус хорооллын халаалтын зуухны өргөтгөл шинэчлэлийн ажил 100.0 сая төгрөг
- Уянга сумын Соёлын төвийн их засвар-134.0 сая төгрөг
- Баян-Өндөр сумын ЕБС-ийн дотуур байрны их засвар-100.0 сая төгрөг
- Тарагт сумын Үржлийн булгийн төмөр бетон гүүр-550.0 сая төгрөг

Санхүүгийн тайланг баталгаажуулах аудитаар ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д “8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно”-д гэсэн заалтыг зөрчсөн сумдад албан шаардлага хүргүүлж биелэлтийг бүрэн хэрэгжүүлж ажилласан талаар 2024 оны 5 сард албан бичгээр ирүүлсэн байна. Үүнд:

-Тарагт сум - Ногоон байгууламжийн хайсан хашаа хийх 20.0 сая төгрөгийн ажил, хайсан хашаа хийх 20.0 сая төгрөгийн ажил 2 нь нэр төрөл ижил ажлыг 2 салган шууд гэрээ байгуулсан, оготно устгалын ажилд бактержуулсан будаа 26.0 сая төгрөгөөр шууд гэрээ байгуулан худалдан авалт хийсэн,

-Хархорин сум - Ижил төрлийн гүний худаг шинээр гаргах 197.9 сая төгрөгийн 7 ажлыг харьцуулалтын арга ашиглан тус тусад нь худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Аудитын илрүүлэлт

1. Баянгол, Нарийнтээл сумд 109.5 сая төгрөгийн ижил төрлийн 7 төсөл, арга хэмжээг ТБОНӨХБАУХА тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д “8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно”-д гэсэн заалтыг зөрчин гэрээ байгуулсан байна.

2. Аймгийн Худалдан авах ажиллагааны газраас зарласан нээлттэй тендерээс 5 тендерийн урилгыг өдөр тутмын сонинд нийтлээгүй байна.

2.1.2. ОНХС-ийн хөрөнгийг зориулалтын дагуу бодит гүйцэтгэлд үндэслэн зарцуулсан ч Хужирт суманд 2021 онд эхэлсэн Төрийн албан хаагчийн орон сууц барих ажил гүйцэтгэл нь 50 хувьтай байхад санхүүжилтийг 91.0 хувь олгосон байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 8.5 дахь заалт “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д зааснаар захиалагч байгууллагын хүсэлтийн дагуу аймаг, нийслэлийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгж, сум, дүүргийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан албан тушаалтан нь бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийн эрхийг олгоно” гэж заасан.



Аймаг, сумдын 2023 онд бүрэн хэрэгжсэн 326 төсөл, арга хэмжээнд 12,763.0 сая төгрөгийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр Хужирт суманд баригдаж эхэлсэн Төрийн албан хаагчийн орон сууц барих ажлын гэрээг 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Сумын Засаг дарга Т.Баярмөнх, “Отгоннинж” ХХК-ний захирал Я.Баасанжав нар 374.0 сая төгрөгөөр гүйцэтгэж, 2022 оны 6 дугаар сарын 10-ны дотор хүлээлгэж өгөхөөр хийсэн. Гэвч 2023 оны 3 дугаар сарын 27-нд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж нэмэлт төсөв 300.0 сая төгрөгөөр төлөвлөн 2023 оны 9 дүгээр сарын 01-ний

дотор гүйцэтгэн хүлээлгэж өгөхөөр хийсэн боловч одоогийн байдлаар барилгын гүйцэтгэл 50.0 хувьтай байна.

Барилгын нийт төсөв нь 674.0 сая төгрөг бөгөөд үүнээс аймгийн ОНХС-аас 270.0 сая төгрөг, сумын орон нутгийн орлогоос 344.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч барилгын ажил зогсонги байдалтай байна.

Аудитын илрүүлэлт

Хужирт суманд 2021 онд эхэлсэн Төрийн албан хаагчийн орон сууц барих ажил гүйцэтгэл нь 50 хувьтай байхад санхүүжилтийг 91.0 хувь олгосон байна.



2.2. Аймаг, сумдын 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 448.3 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээ чанаргүй хийгдсэн байна.


2.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ төлөвлөсөн зорилтод түвшинд хүрсэн боловч зарим төсөл, арга хэмжээ чанаргүй хийгдсэн байна.

Аймгийн хэмжээнд нийт 453 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 14,491.1 сая төгрөгийн 361 ТАХ гэрээ байгуулагдсанаас 12,763.0 сая төгрөгийн 326 ТАХ бүрэн хэрэгжсэн, 1,728.1 сая төгрөгийн 35 ТАХ хэрэгжилтийн шатанд байгаа бол 2,744.6 сая төгрөгийн 92 ТАХ малын тоо толгойн албан татварын орлого бүрэн төвлөрөөгүй шалтгаанаар хэрэгжээгүй байна.


Нийт бүрэн хэрэгжсэн төсөл, арга хэмжээнд 12,763.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон бол дутуу хэрэгжсэн төсөл, арга хэмжээнд 535.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ төлөвлөсөн зорилтод түвшинд хүрч, үр дүнгээ өгсөн боловч дараах ажлууд чанаргүй хийгдсэн байна. Үүнд:

- Баянгол сумын ЕБС-ийн гал тогооны хоол үйлдвэрлэлийн өрөөг засварлахаар нийт 10.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд гүйцэтгэлд үндэслэн 8.0 сая төгрөгийг санхүүжүүлсэн боловч уур сорох тоног төхөөрөмж нь техникийн тодорхойлолтоос зөрсөн, уураа сорохгүйгээс мөөгөнцөртөж засварын ажил үр дүнгүй болсон
- Баянгол сумын ЕБС-ийн дотуур байрны халуун ус, угаалга, хатаалгын өрөөг тохижуулахаар 14.8 сая төгрөгийн гэрээ байгуулан гүйцэтгэлд үндэслэн 11.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон бөгөөд чанаргүй болсон байна. БШУЯ-аас ЕБС, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг шинэчилж ариун цэврийн байгууламжтай болгохоор санхүүжилтийг Эрдэнэт ТӨҮГ-аас нийгмийн хариуцлагын хүрээнд шийдвэрлэгдэж байгаа төслийн хүрээнд 2024 онд шинээр ариун цэврийн өрөөний ажил хийгдэж байгаа тул тус ажил хэрэгцээ шаардлагагүй ажил болсон байна.
- Баянгол сумын ЕБС-ийн дээврийн засвар нь аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 100.0 сая төгрөгөөр хийгдсэн бөгөөд чанаргүй хийгдсэн тул зарим хэсгээрээ хуйларсан, дусаал гоожсон байдалтай байна.
- Гучин-Ус сумын сургуулийн дотуур байрны засвар 70.0 сая төгрөгөөр хаалга-21ш, цонх-28ш, шалны хулдаас сольсон байна. Засварын ажил чанар байдлын хувьд муу хийгдсэн байна. Дуутын нуруу ХХК дээврийн засварыг 2022 онд хийж гүйцэтгэсэн ч дусаал гоожиж чанаргүй хийгдсэн байна.
- Есөнзүйл сумын 5.0 сая төгрөгийн цагдаагийн байрны засвар
- Хайрхандулаан сумын ЕБС-ийн стандартад нийцсэн хүнсний агуулахтай болох хуучин агуулахыг засварлах ажил 53.5 сая төгрөгөөр хийгдсэн бөгөөд агуулах нь анх гар аргаар 2004 онд хийгдсэн, хар таазны дам нуруу хотойж уналт өгсөн байсныг анх тооцоогүйн улмаас техникийн тодорхойлолт заасны дагуу зарим ханыг буулгаж өрөөг томсгох ажил хийгдэх боломжгүй болсон
- Баян-Өндөр суманд аймгийн ОНХС-аас 89.5 сая төгрөгөөр хийгдсэн дотуур байрны дотор засвар маш муу хийгдсэн бөгөөд сольсон хаалга нь бүгд зайтай болоод ашиглалтын шаардлага хангахгүй болсон байна.
- Аймгийн ОНХС-аас 105.5 сая төгрөгөөр хийгдсэн Арвайхээр сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн гадна засвар чанаргүй хийгдсэнээс будаг нь гандсан байна.



Баянгол сумын ЕБС-ийн дотуур байрны халуун ус, угаалга, хатаалгын өрөөг тохижуулах ажил



Баянгол сумын ЕБС-ийн дотуур байрыг ариун цэврийн байгууламжтай болгох ажил



Баянгол сумын ЕБС-ийн гал тогооны хоол үйлдвэрлэлийн өрөөний засвар




Баянгол сумын ЕБС-ийн дээврийн засвар

Аудитын илрүүлэлт

1. Аймаг, сумдын 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 448.3 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээ чанаргүй хийгдсэн байна .

2.2.2.ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ээс иргэдэд хамгийн их үр өгөөжөө өгч байгаа сайн жишээнүүдээс дурдвал:

- Баян-Өндөр сумын Хүн эмнэлэгт шүдний кабинет байгуулж, тоног төхөөрөмжөөр хангасан тул иргэдийн шүд цоорол өвчлөл эрс буурсан байна. Мөн заавал аймгийн төв орж шүдээ үзүүлэх шаардлагагүй зардал мөнгө хэмнэгдэх боломж бүрдсэн байна.
- Аймгийн төвийн хогийн цэгийг цэгцлэн биологийн нөхөн сэргээлт хийж ногоон байгууламж бий болгосон байна.
- Аймгийн төвийн 4 зүгт өндөрлөг дээр гэр хороолол, нийтийн эзэмшлийн талбайд 360 эргэдэг хүчин чадал сайтай камер суурилуулснаар гэмт хэрэг зөрчил илрүүлэх, бусад ажилд ашиглах давуу байдал бий болсон байна.
- Зүүнбаян-Улаан сумын ЕБС-д Монгол бичгийн кабинет байгуулж, хүүхдийн сурч боловсрох орчныг сайжруулснаар үндэсний эх хэлээ сурах нөхцөл боломжийг бүрдүүлсэн байна.
- Гучин-Ус сумын 3-р багийн төвийн барилга-36.0 сая төгрөг
- Хайрхандулаан сумын 14.9 сая төгрөгөөр хийгдсэн хүүхдийн тоглоомын талбай нь чанар байдлын хувьд сайн бөгөөд чөлөөт цагийг зөв өнгөрүүлэх боломжийг бүрдүүлсэн байна.
- Баянгол сумын гудамж талбайн гэрэлтүүлгийн нэмэгдүүлэх камер тавих ажил 19.5 сая төгрөг



ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний дийлэнх хувийг богино хугацааны хэрэгцээ, шаардлага хангах хэт жижиг олон төсөл, арга хэмжээг санхүүжүүлж байгаа нь материаллаг дүн багатай боловч орон нутагт томоохон үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжиж, бодитой үр дүн үзүүлэх боломжийг хааж байгааг анхаарах нь зүйтэй байна.

Зарим ажлууд үр нөлөөгүй урсгал засварын шинжтэй ажлууд хийгдсэн байна. Тухайлбал: Арвайхээр сумын Нийтийн тээврийн ашиглалтыг сайжруулах, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх ажил 69.3 сая төгрөгөөр хийгдсэн боловч үйлчилгээний машины урсгал засварт зарцуулагдсан байна.

2.3. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон зарим ТАХ гэрээнд заасан хугацаанд хийж дуусгаагүй, хүлээн авч ашиглалтад оруулаагүй байна.

2.3.1. ОНХС-ийн 2023 оны санхүүжилтээр ихэнх сумууд ногоон байгууламж бий болгох, гэрэлтүүлэг, камержуулалтын ажил хийх, газар тариалангийн тоног төхөөрөмж худалдан авах, Хүүхдийн цэцэрлэг, хүн эмнэлэгт тоног төхөөрөмж нийлүүлсэн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн зарим гүйцэтгэгч нар нь гэрээнд заасан хугацаанд бараа, ажил, үйлчилгээг бүрэн хийж дуусгаагүй, захиалагч хэрэгцээ шаардлагыг бодитой төлөвлөөгүйгээс зарим хөрөнгө ашиглалтгүй байна. Үүнд:

- Гучин-Ус сумын гэр хорооллыг дулааны шугам сүлжээнд холбох ажилд аймаг, сумын ОНХС-аас 296.2 сая төгрөгийн санхүүжилт авч хийсэн. Гэвч гэр хорооллын айл өрхүүд тус шугамаас хэзээ яаж холболтоо авч ашиглах нь тодорхойгүй байна.
- Тарагт сумын Гэрэлтүүлгийн ажил 6.0 сая төгрөгөөр хийгдсэн боловч чанаргүй хийгдсэн тул ашиглалтгүй байна.
- Тарагт сумын Хүүхдийн цэцэрлэгийн гаднах тоглоом суурилуулах ажил 11.3 сая төгрөгөөр хийгдсэн боловч нийлүүлэгч нь ирж угсраагүй агуулахад хураалттай байна.
- Хужирт сумын 2-р цэцэрлэгийн хүнсний агуулах барих ажил 19.6 сая төгрөгөөр хийгдсэн боловч чанар муу болсон, дахин засах шаардлагатай байна.

- Арвайхээр сумын нийтийн бие засах газар 47.8 сая төгрөгөөр баригдсан боловч сууж ажиллуулах хүн олдохгүй одоогоор ашиглалтгүй байна.
- Хүнсний ногооны зориулалттай 50 тн хүчин чадалтай зoorь 2022 оны ОНХС-ийн хөрөнгөөр тус бүр нь 40.0 сая төгрөгөөр Бат-Өлзий, Есөнзүйл сумдад баригдсан боловч хөлдөлт үүссэний улмаас ашиглалтгүй байна.
- Хужирт сумын нийтийн бие засах газар 12.4 сая төгрөгөөр хийгдсэн ч ашиглалтгүй байна.
- Хужирт сумын 4-р цэцэрлэг нь 2 бүлэгтэй 50 хүүхэдтэй боловч 2 тасалгаатай хүнсний агуулах 15.0 сая төгрөгөөр барьсан нь огт хэрэгцээ шаардлагагүй, ашиглалтгүй байна.
- Баруунбаян-Улаан сумын ЕБС, Хүн эмнэлэгт 20.0 сая төгрөгөөр цэвэр усны баллон төхөөрөмж суурилуулсан боловч ашиглалтгүй байна.

Аудитын илрүүлэлт

Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон ТАХ-ээс 2022-2023 онд ашиглалтгүй нийт 508.3 сая төгрөгийн зөрчил гаргасныг илрүүлж холбогдох байгууллага, албан тушаалтнуудад 2023 онд хэрэгжсэн 8 төрлийн 428.3 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

2.3.2. Зарим сумын ОНХС-ийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийн хадгалалт хамгаалалт муугаас, эвдэрч хэмхэрсэн байдалтай байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн зарим ТАХ-ний хадгалалт хамгаалалт хангалтгүй байна.¹¹ Үүнд:

- Арвайхээр сумын 8, 12 дугаар багт 2022 онд 98.5 сая төгрөгөөр он дамжиж хийгдсэн хүүхдийн тоглоомын талбайн зарим нь эвдэрсэн байна.
- Арвайхээр сумын 6 дугаар багт 2023 онд 46.5 сая төгрөгөөр хийгдсэн хүүхдийн тоглоомын талбайн зарим хийсэн ажил нь хулгайд алдагдсан, мод суулгалтын ажил хийгдээгүй байна.

Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон нийтийн эзэмшлийн хөрөнгийн урсгал зардал, засвар үйлчилгээг хийх төсөв хөрөнгийг ашиглагч байгууллагын төсөвт баталдаггүйгээс хөрөнгийн хадгалалт, хамгаалалт хангалтгүй байна. Тухайлбал: Өмнөх онуудад хийгдсэн зарим гэрэлтүүлэг, камержуулалт, хайс хашаа зэрэг ажлууд нь эвдэрч хэмхэрсэн байдалтай байна.



¹¹ Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 9.12-д ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга, байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцна.

Аудитын илрүүлэлт

Аудитаар ОНХС-ийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалттай холбоотой 145.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж, холбогдох албан тушаалтанд албан шаардлага хүргүүлсэн.

Бүлэг 3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, тайлагнах ажлыг аймаг болон зарим сумд хэрэгжүүлж ажиллаагүйгээс зарим ажил чанаргүй хийгдэж он дамжин хэрэгжиж байна.

3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад аймгийн ИТХ, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт тавьж ажиллаагүй байна.

3.1.1. Сумдад жил бүр ОНХС-ийн санхүүжилт хуваарилж, зарцуулалтад нь ИТХ-аас хяналтыг хэрэгжүүлж ирсэн. Гэвч 2023 онд хэрэгжсэн ТАХ-ний гүйцэтгэлд аймгийн ИТХ, Хужирт, Хархорин сумдын ИТХ хяналт тавьж ажиллаагүй байна.

Гучин-Ус, Өлзийт, Сант, Уянга, Баруунбаян-Улаан сумдын ИТХ-ын хяналт хийсэн тайлан хангалтгүй байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас ОНХС-ийн 2023 онд хэрэгжүүлсэн ТАХ-нд дотоод хяналт хийгдээгүй байна.

Аудитын илрүүлэлт

ОНХС-ийн санхүүжилтээр 2023 онд хэрэгжсэн ТАХ-ний гүйцэтгэлд аймгийн ИТХ, Хужирт, Хархорин сумдын ИТХ хяналт тавьж ажиллаагүй байна.

3.1.2. Захиалагч, ашиглагч байгууллагын зүгээс төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Их засварын ажлыг хүлээн авахдаа Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 4 дүгээр хавсралтад заасны дагуу комиссын гишүүдийн өгсөн санал, үүрэг даалгаврын биелэлтийг үндэслэн хүлээн авсан байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 9 төсөл, арга хэмжээнд хийгдэх хяналтыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар хэрэгжүүлж ажилласан. Тухайлбал: Шинээр баригдсан Есөнзүйл сумын Төрийн албан хаагчийн 207.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилгын ажлын чанар байдал хангалтгүй учир үүрэг даалгавар өгч, хүлээж аваагүй байна.

Сумууд өөр өөрсдийн ТАХ-нд захиалагчийн хяналтыг тавьж ажилласан байна. Тухайлбал: Арвайхээр сумын гэр хороолол, нийтийн эзэмшлийн талбайн камерын тоог нэмэгдүүлэх ажил техникийн тодорхойлолтод заасан үзүүлэлтэд хүрэхгүй байсан тул ашиглагч тал дахин буцааж үзүүлэлтийн дагуу хүлээж авсан байна.

Мөн “Тогтвортой амьжиргаа 3” төслөөс ОНХС-ийн үйл ажиллагааг сайжруулах, тус сангийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 19 сумын ОНХС-ийн үйл ажиллагаанд жилийн гүйцэтгэлийн үнэлгээ хийж, дүгнэн Богд, Хархорин сумд хамгийн өндөр урамшуулал авсан байна.

3.1.3. ОНХС-ийн орлого бүрдүүлэлт, зарцуулалттай холбоотой өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмж 100 хувь бүрэн биелэгдсэн байна. Үүнд:

- Малын тоо толгойн албан татварын тухай хуультай холбоотой 16 төрлийн 307.9 сая төгрөгийн акт



- Гэрээний үндсэн дээр хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажлын урьдчилж төлсөн зардлыг бүртгээгүй 9 төрлийн 295.6 сая төгрөгийн зөвлөмж
- Удирдлагын мэдээллийн системд зөрүүтэй мэдээлсэн, бусад төрлийн 142 зөвлөмж
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, хөрөнгийн ашиглалт, чанар байдалтай холбоотой 42 төрлийн 5033.5 сая төгрөгийн албан шаардлага тус тус хэрэгжиж үр дүнгээ өгч дээрх алдаа зөрчлүүд дахин гараагүй байна.

3.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтээ үнэн зөв, журмын дагуу тайлагнаагүй, зарим ТАХ дуусаагүй тул тайлан, бүртгэлд тусгаагүй байна.

3.2.1 Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.2, 9.3, 9.9, 9.10, 9.11 дүгээр бүлэгт ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайлан гаргах, хүргэх зохицуулалтыг тусгасан байна.¹² Гэвч аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-ний хэрэгжилтийн тайланг аймаг, сумдаар үнэн зөв гаргаж журамд зааснаар нэгтгээгүй байна.

Хүснэгт-11 Тайлан хүргүүлэх хугацаа, мэдээлэл

Хариуцах нэгж, албан тушаалтан	Тайлагнах хугацаа	Хүргүүлэх албан тушаалтан	Тайланд тусгах мэдээлэл	Тайланд дүн шинжилгээ хийж, хэрэгжүүлэх арга хэмжээ
9.2/9.3 заалт Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга	Дараа оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор	Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг хүргүүлнэ.	9.9.1.ОНХС-ийн тухайн оны батлагдсан төсөв, санхүүжилт нь эх үүсвэр бүрээр; 9.9.2.ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт нь хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тус бүрээр; 9.9.3.ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэр, байршил, ажлын гүйцэтгэлийн хувь, эхлэх, дуусах хугацаа; 9.9.4.Шинээр бий болсон барилга байгууламж, гүйцэтгэсэн их засварын ажил, нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн гэрэл зураг, тэдгээрийг өмчлөлд бүртгэснийг баталгаажуулсан баримт; 9.9.5.Он дамжин хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалт;	1. ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сум, дүүрэг тус бүрээр гарган, дүгнэлт өгч, цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж, холбогдох асуудлаар тодорхой шийдвэрийг гаргуулна. 2. Засаг даргын шийдвэрийг тухайн шатны ИТХ-аар жил бүр, төсвийн гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлангийн талаарх Засаг даргын мэдээллийн хамт хэлэлцүүлнэ.

^{12 12} Журмын 9.2 дахь заалт: Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх ба энэ журмын 9.9-д заасан мэдээллийг багтаана.

¹² Журмын 9.9 дэх заалт: Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан нэгжид ирүүлэх бөгөөд тайланд дараах мэдээллийг тусгана...



<p>9.9/ 9.10 заалт</p> <p>Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс</p>	<p>Жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор</p>	<p>Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан нэгжид аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг хүргүүлнэ.</p>	<p>9.9.6.ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн сайн туршлага, жишээ, оновчтой санал;</p> <p>9.9.7.Энэ журмын 9.4, 9.5-д дурдсан байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, дүгнэлт, акт болон албан шаардлагын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай танилцуулга.</p>	<p>Тайланд дүн шинжилгээ хийж, ОНХС-ийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр бодлого боловсруулна.</p>
---	---	---	--	---

Эх сурвалж: 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам

Аудитын илрүүлэлт

Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд санхүүжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ нь сум тус бүрээр журмын 9.9-д заасан мэдээллээр бүрэн гаргуулж аваагүй зөрчил илэрсэн.

Сумууд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланд журам, зааврын дагуу шинээр бий болсон барилга байгууламж, гүйцэтгэсэн их засварын ажил, нийлүүлсэн тоног төхөөрөмжийг өмчлөлд бүртгэснийг баталгаажуулсан баримт, сайн туршлага, жишээ оновчтой санал зэргийг тусгаж тайлагнаагүй байна.

3.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг ихэнх сумууд нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан байна.

Аудитын илрүүлэлт

ОНХС-ийн санхүүжилтээр хийгдсэн зарим барилга байгууламж, засварын ажил, хөрөнгө оруулалтын ажил дуусаагүй, чанаргүй хийгдсэн тул данс бүртгэлд бүрэн тусгаагүй байна. Үүнд:

- Уянга суманд 30тн багтаамжтай гүн хөлдөөгчтэй мал нядалгааны цех баригдаж байгаа 179.5 сая төгрөг /ГХБХБГ/
- Бат-Өлзий суманд 30тн багтаамжтай гүн хөлдөөгчтэй мал нядалгааны цех баригдаж байгаа 175.1 сая төгрөг
- Баянгол суманд 30тн багтаамжтай гүн хөлдөөгчтэй мал нядалгааны цех баригдаж байгаа 175.1 сая төгрөг
- Бат-Өлзий сумын Ерөнхий боловсролын сургуулийн Спорт залны дээврийн засварын ажил 40.0 сая төгрөг
- Баян-Өндөр сумын өв соёл, түүхэн дурсгалыг мөнхжүүлэх ажилд 15.0 сая төгрөг
- Есөнзүйл суманд Иргэдэд тав духтай орчин бүрдүүлэх, албан хаагчийн байр барих 207.8 сая төгрөг
- Есөнзүйл сумын Сэрүүн булагт амралтын байр барих 15.9 сая төгрөг
- Өлзийт сумын Хуучин ЕБС-н ашиглагдахгүй 3-н өрөөг багийн төвийн зориулалтаар засварлах ажил 62.5 сая төгрөг
- Тарагт сумын Ногоон байгууламжийн хайсан хашаа барих ажил 20.0 сая төгрөг
- Тарагт сумын гэрэлтүүлгийн ажил 6.0 сая төгрөг
- Тарагт сумын гудамжны гэрэлтүүлэг 14.0 сая төгрөгөөр 2022 онд хийсэн ажил
- Тарагт сумын хайсан хашаа хийх ажил 20.0 сая төгрөг
- Тарагт сумын СӨББ-ын гадна талбайн тоглоом 11.3 сая төгрөг
- Арвайхээр сумын 9-р багийн тоглоомын талбайн тохижилтын 46.5 сая төгрөгийн ажил дуусаагүй, моджуулах ажил хийгдээгүй байна.

- Арвайхээр сумын Гэр хорооллын, нийтийн эзэмшлийн талбайн камерын тоог нэмэгдүүлэх 59.3 сая төгрөгийн ажил хүлээж аваагүй байна.
- Хайрхандулаан сумын нийтийн эзэмшлийн талбайд лед дэлгэц хийх 35.0 сая төгрөгийн ажил
- Хужирт сумын Төрийн албан хаагчийн орон сууц шинээр баригдаж байгаа 674.0 сая төгрөг

Зарим байгууллага хөрөнгийг бүртгэлд бөөн дүнгээр буруу тайлагнаж орлого авсан байна. Тухайлбал:

- БОЭТөвд Хүүхдийн эмнэлэгт хүчил төрөгчийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг бөөн дүнгээр буюу 249.0 сая төгрөгөөр орлого авсан байна.
- Хархорин сумын ЗДТГ-т үндсэн хөрөнгө бүртгэлд авсан 139.1 сая төгрөг
- Есөнзүйл сумын Хүүхдийн цэцэрлэгийн гаднах тоглоом 9.8 сая төгрөг
- Есөнзүйл сумын Соёлын төвд авсан номын үнэ 2.0 сая төгрөг
- Сант сумын ЕБС-ийн гадна спортын талбайн тохижилтын ажлыг 47.6 сая төгрөг

Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон 1757.0 сая төгрөгийн 17 хөрөнгийг чанартай гүйцэтгүүлж, дуусган, ашиглалтад авч, орон нутгийн өмчид бүртгэх албан шаардлага, 447.5 сая төгрөгийн 5 зөрчлийг залруулах зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн.

3.2.3. Ихэнх сумд ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаарх мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд үнэн зөв оруулж, иргэдэд ил тод нээлттэй мэдээлсэн боловч аймгийн ОНХС-ийн мэдээллийг УМС-д оруулаагүй байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 10 дугаар бүлэгт ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт, бүртгэлийг Удирдлагын мэдээллийн системд бүртгэх талаар тусгаж, иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлэх үүргийг заасан.

Баян-Өндөр, Бүрд, Бат-Өлзий, Баруунбаян-Улаан, Гучин-Ус, Өлзийт, Хайрхандулаан, Зүүнбаян-Улаан, Сант, Төгрөг, Богд, Арвайхээр сумд Удирдлагын мэдээллийн системд бүрэн гүйцэт журмын дагуу мэдээллийг оруулсан байна.

Харин аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр бүрэн хэрэгжсэн 47 төрлийн 6,524.9 сая төгрөгийн ТАХ-ээс, 12 төрлийн ТАХ-ний мэдээллийг дутуу оруулсан, 35 төрлийн 2154.1 сая төгрөгийн ТАХ-ний мэдээллийг огт оруулаагүй байгаа нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын ¹³10.2.ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт, бүртгэлд УМС ашиглах ба бүртгэнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна. Мэдээллийг үнэн зөв бүрэн оруулаагүйгээс иргэд мэдээлэл авах боломж бүрдэхгүй байна.

ОНХС-ийн www.onhs.mof.gov.mn удирдлагын мэдээллийн системээс аймаг болон сумын ОНХС-ийн эх үүсвэрээр санхүүжсэн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээний


¹³ 10.2.1.Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тухайн шатны ИТХ-аас баталсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор ОНХС-ийн УМС-д оруулна;

10.2.2.ОНХС-аас аймаг, нийслэлд шилжүүлэх орлогын шилжүүлгийн сар, улирлын батлагдсан хуваарийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС хариуцсан нэгж жил бүрийн 1 дүгээр сарын 5-ны өдрийн дотор ОНХС-ийн УМС-д оруулна;

10.2.3.Аймаг, нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэс нь орон нутгийн төсвийн батлагдсан сар, улирлын хуваарьтай нийцүүлэн ОНХС-ийн сум, дүүргээр хуваарилан баталсан сар, улирлын хуваарийг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ОНХС-ийн УМС-д оруулна;

10.2.4.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС хариуцсан нэгж нь ОНХС-ийн орлогын шилжүүлгийг Төв төрийн сангийн сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ гарсны дараа ажлын 5 хоногийн дотор аймаг, нийслэлийн ОНХС-ийн дансанд шилжүүлж, ОНХС-ийн УМС-д бүртгэнэ;

10.2.5.Аймаг, нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэс хуваарилагдан ирсэн орлогын шилжүүлгийг ажлын 2 өдөрт багтаан батлагдсан хуваарийн дагуу сум, дүүрэгтээ хуваарилж, ОНХС-ийн УМС-д бүртгэнэ.



төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилтийн талаарх мэдээллийг авах боломжтой хэдий ч санал асуулгаар иргэд мэдээлэл дутмаг байгаа нь харагдаж байна. Иймээс иргэдийг мэдээллээр ханган, тэдгээрийн оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллах шаардлагатай байна.

3.2.4. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын талаарх мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн байршуулаагүй зөрчлийг арилгаж биелэлтийг ирүүлсэн байна.

СТА-аар 2023 оны ОНХС-ийн Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг бүрэн оруулсан эсэхийг шалгахад 7 сум нийт 4980.7 сая төгрөгийн мэдээллийг бүрэн байршуулаагүй, оруулсан мэдээлэл нь бүрэн бус, хангалтгүй зэрэг зөрчил илэрсэнд албан шаардлага өгч, биелэлтийг тооцож ажилласан. Үүнд:

Бат-Өлзий сум - Хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой гарсан 21.3 сая төгрөгийн 3 тушаал шийдвэрийг байршуулаагүй, 5 сая төгрөгөөс дээш орлого зарлагын 1405.6 сая төгрөгийн 24 гүйлгээг дутуу мэдээлсэн

Нарийнтээл сум - Хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой гарсан 248.7 сая төгрөгийн 7 тушаал шийдвэрийг байршуулаагүй, 5 сая төгрөгөөс дээш орлого зарлагын 408.6 сая төгрөгийн 12 гүйлгээг дутуу мэдээлсэн

Баянгол сум - Хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой гарсан 102.4 сая төгрөгийн 14 тушаал шийдвэрийг мэдээлээгүй

Хужирт сум - Хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой гарсан 477.0 сая төгрөгийн 20 тушаал шийдвэрийг байршуулаагүй, 115.0 сая төгрөгийн 2 тендерийн мэдээллийг оруулаагүй, 5 сая төгрөгөөс дээш орлого зарлагын 508.9 сая төгрөгийн 29 гүйлгээг дутуу мэдээлсэн

Бүрд сум - Хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой гарсан 245.1 сая төгрөгийн 7 тушаал шийдвэрийг байршуулаагүй, 227.2 сая төгрөгийн 5 тендерийн мэдээллийг оруулаагүй, 5 сая төгрөгөөс дээш орлого зарлагын 159.0 сая төгрөгийн 7 гүйлгээг дутуу мэдээлсэн

Төгрөг сум - Хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой гарсан 83.5 сая төгрөгийн 2 тушаал шийдвэрийг байршуулаагүй, 5 сая төгрөгөөс дээш орлогын 251.0 сая төгрөгийн 10 гүйлгээг дутуу мэдээлсэн

Сант сум - Хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой гарсан 278.7 сая төгрөгийн 18 тушаал шийдвэрийг байршуулаагүй, 5 сая төгрөгөөс дээш орлого зарлагын 448.9 сая төгрөгийн 22 гүйлгээг дутуу мэдээлсэн

Дээрх зөрчлүүд дахин давтагдаж гараагүй бөгөөд Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна.



ДҮГНЭЛТ

- Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан боловч сумдын ОНХС-ийн бусад орлогыг хуульд заасан эх үүсвэрээр бүрэн төлөвлөөгүй байна
- Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөсөн ч иргэдийн саналаар эрэмбэлэгдээгүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ төлөвлөсөн зорилтод түвшинд хүрсэн боловч зарим төсөл, арга хэмжээ чанаргүй хийгдсэн байна.
- ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн зарим гүйцэтгэгч нар нь гэрээнд заасан хугацаанд ажлаа бүрэн хийж дуусгаагүй, захиалагч хэрэгцээ шаардлагыг бодитой төлөвлөөгүйгээс зарим хөрөнгө ашиглалтгүй байна.
- ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон зарим ТАХ-ний хадгалалт, хамгаалалттай хангалтгүй байна.
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний хэрэгжилтийн тайланг аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ нь журмын дагуу нэгтгэж тайлагнаагүй байна.
- Зарим ТАХ чанар байдал, хүйтний улирлаас шалтгаалж дуусаагүй, хүлээж аваагүй, бүртгэл тайланд тусгаагүй байна.

САНГИЙН ЯАМАНД САНАЛ:

1. Төсвийн тухай хуульд ОНХС-ийн орлого төлөвлөлт, эх үүсвэртэй холбоотой заалтууд өөрчлөгдсөн боловч Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал"-д нэмэлт өөрчлөлтүүдийн оруулаагүй байна.
2. МУЗГ-ын 2017 оны 230 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "ОНХС-аас олгох орлогын шилжүүлэг тооцох аргачлал", Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам", Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-д Төсвийн тухай хуульд орсон өөрчлөлтүүд тусгагдаагүй. Тус хууль, журмуудын хоорондын уялдаа хангалтгүй байгаад өөрчлөлт оруулах саналыг хүргүүлж байна.



ЗӨВЛӨМЖ

Аймгийн ИТХ-ын дарга О.Пүрэвдорж танаа:

Аймгийн ИТХ-аас аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон ТАХ-ны санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажиллах, сумдын ИТХ-ын ажлыг жилийн эцэст дүгнэхдээ шалгуур үзүүлэлт болгон оруулах.

Засаг дарга И.Доржсүрэн танаа:

Аймгийн ОНХС-ийн санхүүжилтээр хийгдэх ажлыг төлөвлөхдөө Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-д заасны дагуу нээлттэй хэлэлцүүлэг явуулж, урьдчилсан жагсаалтыг олон нийтэд хүртээмжтэй хүргэж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар заасан хугацаанд хэлэлцүүлж байх.

Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга Б.Мөнхбат-д:

- ✓ Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-д заасан холбогдох заалтын дагуу ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайлан, мэдээг хугацаанд нь үнэн зөв гаргаж холбогдох байгууллагад хүргүүлж байх.
- ✓ Аймгийн ОНХС-ийн хөрөнгийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт, бүртгэлийн мэдээллийг УМС-д үнэн зөв оруулж, иргэдэд ил тод мэдээллээ хүргэх.

Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга Ц.Идэрсайхан-д:

Аймгийн СТСХ нь төсвийн төслийг хүлээн авахдаа сумдын ОНХС-ийн санхүүгийн тайланд тусгагдсан 1,054.9 сая төгрөгийн бусад авлагыг ОНХС-ийн эх үүсвэрт бүрэн тусгуулан, төлөвлөх.

Аймгийн ГХБХБГ-ын дарга Т.Ариунболд-д:

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 30 тн багтаамжтай гүн хөлдөөгчтэй мал нядалгааны цех Баянгол суманд 175.1 сая, Бат-Өлзий суманд 175.1 сая, Уянга суманд 179.5 сая төгрөгөөр, Бат-Өлзий сумын Ерөнхий боловсролын сургуулийн Спорт залны дээврийн засвар 40.0 сая, Есөнзүйл суманд Иргэдэд тав духтай орчин бүрдүүлэх, албан хаагчийн байр 207.8 сая төгрөгөөр баригдаж байгаа нийт 777.5 сая төгрөгийн ТАХ-нд хяналт тавьж, хүлээн авч бүрэн ашиглалтад оруулах.

Аймгийн Худалдан авах ажиллагааны газарт

Аймгийн Худалдан авах ажиллагааны газраас зарласан нээлттэй тендерийн урилгыг өдөр тутмын сонинд нийтэлж байх.

Аймгийн Орон нутгийн өмчийн газарт

ОНХС-ийн санхүүжилтээр 2023 онд бий болсон 5 төрлийн 447.5 сая төгрөгийн хөрөнгийг буруу тайлагнасан тул анхан шатны баримт үндэслэн хөрөнгө тус бүрээр салгаж, хагас жилийн тайлангаар залруулга хийж бүртгэлд тусгуулах.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Хавсралт-1

Аймгийн ОНХС-аас иргэдийн саналд тусгаагдаагүй 27 төрлийн 3,741.32 сая төгрөгийн ажлыг төлөвлөж баталсан байна. Үүнд:

№	2023 оны ИТХ-аар баталсан ТАХ-ний нэр	Төлөвлөгөө
1	Арвайхээр хотын шинэ суурьшлын бүсэд шинээр байгуулах Цэцэрлэгт хүрээлэнгийн гадна шугам сүлжээ, цахилгаа, унадаг дугуйн замын тохижилтын ажил	666.00
2	Арвайхээр хотын 1,9 дүгээр багийн авто замыг улсын чанартай А0302 дугаар авто замтай холбох	677.00
3	30тн багтаамжтай гүн хөлдөөгчтэй мал нядалгааны цех /Уянга сум/	180.00
4	30тн багтаамжтай гүн хөлдөөгчтэй мал нядалгааны цех /Бат-Өлзий сум/	180.00
5	30тн багтаамжтай гүн хөлдөөгчтэй мал нядалгааны цех /Баянгол сум/	180.00
6	Хаус хорооллын халаалтын зуух, тоног төхөөрөмжийг худалдан авах (Хархорин сум)	35.00
7	Төгрөг сумын Засаг даргын Тамгын газрын дотор сантехникийн засвар	65.00
8	Мал эмнэлгийн газрын лаборатори, конторын барилгын гадна засвар	85.00
9	Бат-Өлзий сумын Ерөнхий боловсролын сургуулийн Спорт залны дээврийн засвар	40.00
10	Аймгийн Хөгжимт драмын театрын дээврийн засвар	30.00
11	Зүүнбаян-Улаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байрны дээврийн засвар	60.00
12	Арвайхээр хотын 10,11 дүгээр багийн авто зам	400.00
13	Гучин-Ус сумын гэр хорооллыг дулааны шугам сүлжээнд холбох	50.00
14	Авто тээврийн төвийн цэвэр усны холболт	19.00
15	Зүүнбаян-Улаан сумын цэцэрлэгийн барилгын дотор засвар	30.00
16	Баян-Өндөр сумын сургуулийн дотуур байрны засвар	100.00
17	Хайрхандулаан сумын соёлын төвийн тоног төхөөрөмж	20.00
18	Богд сумын 2 дугаар сургуулийн технологийн кабинет	40.00
19	Есөнзүйл сумын дотуур байрны засвар	70.00
20	Баянгол сумын сургуулийн хэсэгчилсэн засвар	100.00
21	Хархорин сумын Шанхын баруун хүрээ хийдийн засварын үлдэгдэл зардал	50.00
22	Гучин-Ус сумын сургуулийн дотуур байрны засвар	70.00
23	Богд, Бүрд, Арвайхээр хотын Тэмүүлэл-Эрдэм, Зүүнбаян-Улаан, Нарийнтээл, Тарагт, Хархорин сумын Гүнзгийн сургуульд физик, Богд сумын 1, 2-р дугаар сургууль, Бүрд, Төгрөг, Уянга сумын 1 дүгээр сургууль, Хайрхандулаан, Хархорин 2-р сургууль болон Гүнзгий, Номын хүрдэн сургуулиудад химийн кабинетын тоног төхөөрөмж	160.00
24	Улаан загалмайн хорооны барилгын гадна фасад засвар	100.87
25	Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн фасад, урлаг заалны засвар шинэчлэл (Арвайхээр сум)	208.71
26	Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт	64.50
27	Эрчим хүчний шугам дэд станцын өргөтгөл (Баян-Өндөр сум)	60.00
Нийт дүн		3,741.32

Монгол улс, Өвөрхангай аймаг
Арвайхээр сум, Нутгийн удирдлагын ордон
Утас: +976 70323253, 70323833, 70323108
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn, цахим хуудас:
www.audit.mn